



2026 оны 8 дугаар сарын 11-ний өдөр

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2026 ОНЫ
ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтад “төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх” тохиолдолд Засгийн газар тухайн жилийн төсвийн тодотголын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэж заасан нь Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

Геополитикийн тодорхой бус байдлаас шалтгаалан Монгол Улсын инфляцын цаашдын төлөвт тодорхой бус байдлыг нэмэгдүүлж байна. Тиймээс цаг үеийн нөхцөл байдалд нийцүүлэн иргэдийн орлого, амьжиргааг хамгаалах арга хэмжээг эрчимжүүлэх шаардлага бий болж байна. Түүнчлэн эрүүл мэндийн салбарт эмч, эмнэлгийн ажилтнуудын хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах шаардлагатай байна.

Энэ хүрээнд эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэхтэй холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагад өөрчлөлт оруулах шаардлага үүсэж байна. Энэ нь иргэдийн худалдан авах чадвар, орлогын тогтвортой байдлыг хамгаалах, эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай тусламж, үйлчилгээний тасралтгүй, хэвийн байдлыг хангахад чиглэнэ.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсвийн ерөнхийлөн захирагчийн орлого, зарлагын хэмжээнд оруулах өөрчлөлтийг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Эрүүл мэндийн салбарын ажилчдын цалин хөлсний өсөлтийг тусламж, үйлчилгээний тарифт тохируулга хийх замаар шийдвэрлэж, сангийн санхүүжилтийг үр ашигтай, оновчтой зарцуулах эрх зүйн орчин бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл байхгүй болно.

---o0o---